

БАТЛАВ:
ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА *D. Sodnom* Д.СОДНОМ



D. Sodnom

2019 оны 05 дугаар сарын 07-ны өдөр

**“АХМАД НАСТАН, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВД ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖ ХУДАЛДАН АВАХ” НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер
шалгаруулалт/
гэрээний нэр, дугаар:

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн
хөгжлийн төвд тоног төхөөрөмж худалдан авах,
ГСАОНӨГ/201902025

Говьсүмбэр

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвд тоног төхөөрөмж худалдан авах”-ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2019 оны 05-р сарын 16-ны өдрийн 09 цагаас өмнө битүүмжилсэн цахим тендер ирүүлэхийг урьж байна.**

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019 оны 05-р сарын 16-ны өдрийн 09 цаг 30 минутад** нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх. “Тооцохгүй”

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3-р баг,
Нутгийн удирдлагын ордон, 3-р давхар,
309 тоот өрөө, Орон нутгийн өмчийн газар,
Утас: 70543033, 95451198**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | | |
|---|------|--|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. | Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. | Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна. |
| | 2.2. | Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. | Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. | Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. | Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана. |
| | 5.2. | Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. | Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 7.1. | Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ. |
| | 7.2. | Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ. |
| | 7.3. | Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай | 8.1. | Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны |

мэдэгдэл

дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ





ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн 1 жилийн санхүүгийн баталгаажсан тайлан /2018 он/ ирүүлэх; 2. Сүүлийн 1 жилийн туршлагын мэдээлэл /биеийн тамир спортын, чийрэгжүүлэх тоног төхөөрөмж нийлүүлсэн барааны гэрээний хуулбар/ ирүүлэх; 3. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар 4. Харилцагч банкны тодорхойлолт /өр зээлийн талаарх мэдээлэл/ 5. Татварын байгууллагын тодорхойлолт 6. Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт 7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт 8. Сүүлийн 1 жилийн борлуулалтын орлого нь санал болгож буй үнийн дүнтэй дүйцэхүйц байх /2018 он/ 9. Бараа нийлүүлэх хуваарийг захирлаар баталгаажуулж ирүүлэх 10. Нийлүүлэгдэж буй тоног төхөөрөмжийн чанарын баталгаат хугацаа 2 жил байна гэдгийг албан мэдэгдлээр буюу захирлын гарын үсгээр баталгаажуулж ирүүлэх 11. Гэрээний ерөнхий болон Тусгай нөхцлийг зөвшөөрч байгаагаа албан мэдэгдлээр ирүүлэх 12. Шалгарсан тохиолдолд “Техникийн тодорхойлолт”-д тусгасан шаардлагуудыг зөвшөөрч байгаа талаар албан мэдэгдэл ирүүлнэ <p>/ТШӨХ-д заасан аль нэг баримт бичгийг дутуу ирүүлсэн тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно мөн дээрх тодорхойлолтуудыг тендер зарлагдсанаас хойш холбогдох газруудаас гаргуулж эх хувиар ирүүлнэ./</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Тендерийн материалыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn хаягаар өөрийн ААН- ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (PDF) файлаар илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 Мб, нэг файлын хэмжээ 15 Мб байна.</p> <p>Тендер хүлээн авах этгээд: Орон нутгийн өмчийн газар Огноо: 2019 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Цаг: 09 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3-р баг, Нутгийн удирдлагын ордон Давхар болон өрөөний дугаар: Орон нутгийн өмчийн газар, 3 давхар, 309 тоот Огноо: 2019 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Цаг: 09 цаг 30 минут</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвд тоног төхөөрөмж худалдан авах”- ГСАОНӨГ/201902025</p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

БАТЛАВ
 АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫ ГАЗРЫН
 ДАРГА  Д.СОДНОМ
 2019 оны 05 дугаар сарын 03-ны өдөр

АХМАД НАСТАН, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВД ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ХУДАЛДАН АВАХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТОО ХЭМЖЭЭ








Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвд тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна. Нийлүүлэгдэж буй тоног төхөөрөмж нь бүгд шинэ, баталгаат хугацаа 2 жил байна.

№	Нийлүүлэгдэх бараан нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тавигдах шаардлага
1	Хаш чулуун ор	ш	1	 Физик эмчилгээний зориулалттай.
2	Мөрний дасгалын төхөөрөмж	ш	1	 7 * 34 * 98 Жин: 17 кг Бүтэц: бариул, тохируулгатай гар тохируулагчтай, Норгосны төхөөрөмжтэй, платформтой
3	Хөлийн дасгалын хэрэгсэл	ш	1	 Хөлийн хөдөлгөөн эрчимжүүлэх, хяналтын самбартай байх
4	Гар хөлийн хөдөлгөөн дэмжих аппарат	ш	1	 Хөл болон нурууны хөшилтийн хэрэгсэлтэй байх








Энэ бол
Энгийн






5	Хөлтэй самбар	ш	2	 <p>Сургалтын зориулалттай /Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулагдсан байна./</p>
6	Хэлхдэг самбар	ш	2	 <p>Гар хурууны хөдөлгөөн сайжруулах зориулалттай /Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулагдсан/</p>
7	3D тоглоом	ш	2	 <p>16 төрлийн дүрстэй, гарын эв дүй сайжруулагч /Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулагдсан/</p>
8	Гарын атгалтыг сайжруулах өнгөт өндөг	ш	20	 <p>Хэмжээ: 5,4*4см /Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулагдсан/</p>
9	Сандал	ш	30	 <p>Тохойвчтой, сайжруулсан түшлэгтэй, суудалтай /Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан/</p>
10	Бүтэн биеийн массажны аппарат	ш	2	 <p>220вт-оор ажилладаг, олон үйлдэлт массажны сандал</p>
11	Хүзүү нурууны массажны аппарат	ш	2	 <p>220вт-оор ажилладаг, 12 вольтоор тохируулж болно.</p>
12	Нүдний массажны аппарат	ш	13	 <p>Бэлтгэлийн зориулалттай жин 260-280гр</p>

Handwritten signature or stamp in blue ink.

13	Ширээ	ш	2	 Хэмжээ:180*60*68см, модон хийцтэй байна.
14	Шкаф	ш	4	 Цайвар саарал өнгөтэй, төмөр, Хэмжээ:185х90х39см
15	Жин өндөр, хэмжигч 120 кг даацтай	ш	2	 Жингийн, өндрийн хэмжих хязгаар: 120кг: 70-190 см тавцангийн хэмжээ: 37,5*27,5см
16	Хөл бүсэлхий, гар нурууны дасгалын хэрэгсэл	ш	5	 Хөл, бүсэлхий, гар, нурууны дасгалын хэрэгслийн иж бүрдэл бүрэн байх
17	Хөлний массажны аппарат	ш	5	 220вт-оор ажилладаг, массажны хүчийг ихэсгэнэ багасгана.
18	Цусны даралт хэмжигч төхөөрөмж	ш	1	 Даралтын хэмжээг тогтмол барих зориулалттай.
19	Өсгөгч	ш	2	 220 волтоор ажилладаг байх, 2018 онд үйлдвэрлэгдсэн дуугаралтын хувьд тохируулгатай байх

Handwritten signature or mark in blue ink.

20	Суурин компьютер	ш	2	 Microsoft AUTHORIZED RESELLER 15 болон түүнээс дээш үзүүлэлттэй байх.
21	Принтер	ш	2	 2017 онд үйлдвэрлэгдсэн HP брэнд эсвэл түүнтэй дүйцэхүйц байх.
22	Гүйлтийн зам	ш	4	 220 v ажилладаг. Хяналтын дэлгэцтэй төрөл бүрийн массаж хийх бүстэй, жин 150 кг дээш даацтай.
23	Хөлний усан массажны аппарат	ш	4	 220вт-оор ажилладаг, 12 вольтоор тохируулж болно.
24	Теннисний ширээ	ш	1	 Стандарт. Торны өндөр 15.25 см. Теннисны 4 хос цохиур, бөмбөгтэй.
25	Унадаг дугуй	ш	4	 Хяналтын дэлгэцтэй 135кг даацтай. Хурдны тохируулгатай, хүндрүүлэгч араатай байх
26	Гэдэсний таталтын унжуу вандан	ш	3	 Хэвтээ байдлаар хэвлийн дасгал хөдөлгөөн хийх боломжтой 130 кг даацтай 130*45*60 см

27	Нөүтбүүк	ш	1	 <p>15 болон түүнээс дээш үзүүлэлттэй байх.</p>
28	Хөдөлгөөний иж бүрдэл	ш	1	 <p>Мөр, цээж, гар, шуу, нуруу, хөл зэрэг бүх төрлийн булчинг хөгжүүлэх зориулалттай иж бүрдэл төхөөрөмж, 200 кг даацтай байх</p>
29	Олон үйлдэлт чийрэгжүүлэлтийн аппарат	ш	4	 <p>152*74 см хэмжээтэй 23 кг жинтэй байх</p>
30	Граунд гольфийн иж бүрдэл	ш	1	 <p>Гольфийн үүр, бөмбөгний суурь, бөмбөг, цохиур тус бүр 8 ширхэгтэй байх</p>
31	Суурин даралтын аппарат	ш	1	 <p>220 волтоор ажилладаг байх 460(Ө) x 310(Ө) x 296(У) , жин: ойролцоогоор 9 кг,</p>

Техникийн тодорхойлолтыг хянасан:

ХОХБТХэлтсийн дарга  /Т.Бат-Эрдэнэ/

НБХэлтсийн дарга  /С.Уранцэцэг/

Техникийн тодорхойлолт боловсруулсан:

ХОХБТХэлтсийн мэргэжилтэн  /Г.Энххишиг/

НБХэлтсийн мэргэжилтэн  /Б.Бурмаа/

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших
1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт
2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх
3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх
4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа
5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа **[моо]** жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах
6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр
7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш **[ГТН-д заасан моо]** хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь
8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах
9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах
10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх
11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **[тоо]**¹ хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
- Гүйцэтгэгчээс ирүүлсэн хүсэлтийг харгалзан Монгол Улсад хүлээн зөвшөөрөгдсөн арилжааны банкнаас ирүүлсэн урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн гэрээний үнийн дүнгийн 30 хүртэлх хувийн урьдчилгаа төлбөрийг гүйцэтгэгчид олгож болно. Ажлын явцад үе шатны гүйцэтгэлээр 40 хувийг санхүүжүүлэх ба ажил дуусч улсын комисст хүлээлгэн өгсөн актыг үндэслэн үлдэгдэл хувийн санхүүжилтийг олгоно.*
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)² 9.1. Алданги оногдуулах хувь: **[тоо]**
- Алдангийн нийт дүн: **[тоо]**

¹ Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны _____ сарын _____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны _____ дугаар сарын _____ -наас _____ оны _____ дугаар сарын _____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]